



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 23 өдөр

Дугаар А/М

Хажуу шинэ-Ус

Газар эзэмших эрхийг шилжүүлэх  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.16 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь заалт, 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх заалтууд, газар эзэмших эрхийг шилжүүлэн авах иргэний хүсэлтийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Говь-Угтаал сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт “Халзан хад” байршилтай 5000м.кв (0.5 га) өвөлжөө, хаваржааны зориулалттай газрын эзэмшигч Рэнцэндавга овогтой Жаргал (ЗВ58071115) нь 2022 оны 01 дүгээр сарын 10 нд нас барсан учир эхнэр Чүлтэмжамц овогтой Тунгалаг (ЗВ59061301)-д тус газрыг зориулалтаар нь шилжүүлж 6 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2.Эзэмшил газраа байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр зориулалтын дагуу эзэмшиж, газрын төлбөрөө цаг тухайд нь төлж байхыг газар эзэмшигч иргэнд үүрэг болгосугай. Газар эзэмшигчийн газрын гэрчилгээг шинэчлэн олгож газар эзэмших гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Н.Лхагва-Учрал)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2015 оны 11 дүгээр сарын 16-ний өдрийн А/119 тоот захирамж иргэн (Р.Жаргал)-д холбогдох хэсэг мөн газар эзэмших 000614743 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Т.АРИУНАА

482401011